



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№132 /346/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.07.29

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ШАЛГАЛТ 2 ДАХЬ ӨДРӨӨ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан "Цэргийн мэргэжлийн зэрэг олгох журам"-ыг үндэслэн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/64 дугаар тушаалын дагуу Цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтыг удирдамжийн дагуу Батлан хамгаалах яам, нийт харьяа байгууллагын хэмжээнд зохион байгуулан явуулж байна. Цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтад хамрагдаж буй нийт

алба хаагчид өчигдөр Батлан хамгаалах яаманд онолын шалгалт буюу ерөнхий тактик, мэргэжлийн бэлтгэл, гадаад хэлний шалгалтуудаа өгсөн бол өнөөдөр Хужир булан дах Зэвсэгт хүчний сургалтын төвд буудлага, биеийн тамирын бэлтгэлийн шалгалтуудаа хамрагдлаа. Уг шалгалтад цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартыг хангасан, цэргийн сургалт бэлтгэлээр "Сайн"-

аас дээш, төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ "Хангалттай" болон түүнээс дээш үнэлэгдсэн, хариуцсан цэргийн нэгтгэл, анги, байгууллага, салбар, алба, тасаг, нэгжийн хувьд сүүлийн хоёр жилийн хугацаанд ажлын хариуцлага алдаагүй, алба хаагч нь захиргааны болон сахилгын ноцтой зөрчил, дутагдал гаргаагүй зэрэг шалгуур үзүүлэлтийг хангасан цэргийн алба хаагч хамрагдах ёстой

юм. Цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтад тэнцсэн цэргийн алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Монгол Улсын Засгийн газраас тогтоосон Цэргийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийг олгоно. Өөрөөр хэлбэл, цэргийн мэргэжлийн III зэрэг эзэмшсэн цэргийн алба хаагчид 5 хувь, II зэрэг эзэмшвэл 10 хувь, I зэрэгтэй бол 15 хувиар тооцож олгох журамтай юм.



АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ХАМТ ОЛОН САЙН ҮЙЛСИЙН АЯНД НЭГДЛЭЭ...



Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын орлогч дарга, Ажиллагааны удирдлагын төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Ц.Батсайханы гэргий Д.Өнөрцэцэг автомашины осолд орж, хоёр ч удаа хагалгаанд орсон боловч дахин сэдэрч, гадаад оронд өндөр өртөгтэй хагалгаанд оруулах шаардлагатай болсон тул мөрдөс нэгт нөхдөөс нь "Цэргийн гэр бүлээ дэмжье" хандивын аяныг өрнүүлээд байгаа билээ.

Энэхүү сайн үйлсийн аянд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын удирдлага, хамт олон нэгдлээ.

Хамт олны цугларсан хандивыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат, хурандаа Ц.Батсайханд дамжуулан өгсөн юм. Энэ үеэр тэрээр хэлсэн үгэндээ "ОХУ-аас Монгол Улсад цэрэг техникийн хамтын ажлын хүрээнд нийлүүлэгдсэн сургууль байлдааны

"МиГ-29УБ" сөнөөгч онгоцыг анх удаа Монгол нисгэгчид Монголынхоо хөх тэнгэрт 29 жилийн дараа хөөргөж, шалгалтын нислэг хийх үйл явдал боллоо. Тус сөнөөгч онгоцыг таны хүү ахлах дэслэгч Б.Хэрлэн жолоодож шалгах нислэгийн үүргээ амжилттай гүйцэтгэснийг онцлоод, хүүд нь ажлын амжилт, гэр бүлд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе" гэв.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	🌧️ 09

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.183.00	3.190.0
EUR 🇪🇺	3.260.0	3.270.0
CNY 🇨🇳	472.50	475.00
RUB 🇷🇺	50.50	51.30
JPY 🇯🇵	23.10	23.30
KRW 🇰🇷	2.39	2.41

ЗУРХАЙ



2022.07.29 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 1

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Нас ахар болно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.25-20.33

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

Суудал: Хий

Энэ өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, эрдэнийг гадагш өгөх, мал худалдан авах, мал түгээх, сахил санваар авах, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 579,780,429

Эдгэрсэн

Нийт: 549,638,534

Нас барсан

Нийт: 6,414,615

Цахим шууданд

ШИНЭЭР 18 АЛБА ХААГЧ ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ШҮХЭР, ДЕСАНТЫН III ЗЭРЭГ ЭЗЭМШЛЭЭ

Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн 2021-2022 оны цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу Архангай аймгийн Өгий нуурт шүхрийн сургалт, дадлагын буултыг амжилттай зохион байгуулав. Энэ үеэр шинээр 18 алба хаагчид цэргийн мэргэжлийн шүхэр, десантын III зэрэг эзэмшүүлэв.

ЗХЖШ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар батлагдсан шүхрийн сургалт дадлагын буултыг зохион байгуулж явуулах дүрмийн дагуу далавчит болон бөөрөнхий гэсэн хоёр төрлийн шүхрээр, анхлан буугч нарт зориулсан танилцах шүхрийн буулт, зэвсэгтэй болон агаарт буудлага хийх, ачаатай буух, усны мандал дээр шүхрээр

буух, хэт нам өндрөөс шүхрээр буух болон бүлгийн буулт гэсэн 6 төрлийн 727 удаагийн буултыг 4 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Сургалтын хүрээнд шүхэрчин дайчдын усанд сэлэх ур чадварыг дээшлүүлэх болон шүхэр эвхэх, шүхрээр буух дадлага ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор цэг онолтын болон усанд сэлэлтийн тэмцээнийг тус тус зохион байгуулав.

Мөн Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн Өгий нуурын эрэг орчмын хог хаягдлыг цэвэрлэж, ард иргэдэд байгаль орчиндоо ээлтэй аялах уриалга бүхий гурван самбарыг нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн юм.

Ө.НАСАНТОГТОХ



БАРУУН АЛТАЙД УРИАНХАЙ, ТУВА ТҮМЭН ЧУУЛЛАА



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Монголын язгуур соёл, зан заншил, өв уламжлал, хэл аялгууны арвин сан хөмрөгтэй Урианхай, Тува түмний соёлын өвийн өдрүүд энэ сарын 25, 26-ны өдрүүдэд Баян-Өлгийн аймгийн Толбо сумын нутаг, Толбо нуурын хөвөөнд ёслол төгөлдөр зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээнд Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Т.Аубакир,

Баян-Өлгий аймгийн Засаг дарга Д.Бауыржан, Говь-Алтай аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Г.Пүрэвганид зэрэг хүндэт зочид хүрэлцэн ирснээс гадна 108 магтаалч, 21 хуурч, бий биелээчид, хөөмийч, ерөөлч, Урианхай, Тува түмнээс төрөн гарсан урлаг соёлын гавьяат, алдартнуудын төлөөлөл, ОХУ, Бүгд найрамдах Тува Улсын уран бүтээлчид,

Хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын бүжигчид, Ховд аймгийн Хөгжимт драмын театр, Говь-Алтай аймгийн Алтай чуулгын уран бүтээлчид оролцож эртний болоод өнөө цагийн их өвийг харуулсан өвөрмөц тоглолтыг сонирхууллаа.

Мөн соёлын биет бус өвийг таниулан сурталчлахын зэрэгцээ түгээн дэлгэрүүлэх сургалтууд, ахуй соёлыг харуулсан үзүүлбэр, уламжлалт спорт, 18 төрлийн

тоглоом наадгайг зохиов.

Энэхүү баяр наадамд Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс Баян-Өлгий аймгийн “Хуушуур фестиваль”-д амжилттай оролцон “Арми хуушуур”-аар нутгийн наадамчин олонд үйлчлэн ажиллаа.

Мөн уламжлалт спорт наадгайн тэмцээн болох “Хорол” тэмцээнд ээлжийн тогооч Т.Наранчимэг ахлагчтай эмэгтэйчүүдийн II баг тэргүүн байрт, “Буган шатар” төрөлд эмэгтэй 5 тамирчин оролцож, ангийн дотрын их эмч энгийн Н.Дэнсээ хоёрдугаар байрт, “Нар сэмбэ” тэмцээнд талхчин Б.Баянзаяа хоёрдугаар байрт, “Үүшүүр”-ийн төрөлд кабельчин монитор Х.Баянхишиг ахлагчтай баг тамирчид 5 дугаар байрт, “Шагай цахлах /зургаадах/” тэмцээнд угаагч П.Наранчимэг тавдугаар байрт, “Унага даага нийлүүлэх” тэмцээнд хүнсний нярав П.Лхагваа зургаадугаар байрт, “Морь уралдуулах” тэмцээнд Б.Энэрэл нэгдүгээр байрт, О.Эрдэнэдалай тусгай байрт тус тус шалгарч амжилттай оролцлоо.

Ийнхүү Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн гайхам өвөрмөц ёс заншил, соёл уламжлалтай Урианхай, Тува түмний наадамд оролцож сайхан наадлаа.

Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

“ААЖУУ ЯВБАЛ АЯНДАА ХҮРНЭ ДЭЭ” АЯНД НЭГДЛЭЭ



Зэвсэгт хүчний 015 дугаар анги

Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон тус дүүргийн Цагдаагийн газар хамтран төрийн байгууллагуудын дунд зохион байгуулж буй “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” нэгдсэн арга хэмжээнд Зэвсэгт хүчний 015 дугаар анги нэгдэн энэ сарын 28-ны өдөр Зэвсэгт хүчний Тээврийн цагдаагийн албанаас “Шилжин явах туг”-ийг хүлээн авлаа.

Тус аяны хүрээнд “Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар” цахим пэйж хуудсыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, нийтлэгдсэн мэдээ мэдээллийг хандалт олонтой бусад цахим хуудсанд хуваалцах, Цагдаагийн байгууллагаас

гаргасан зурагт хуудсыг хэвлэж ангийн мэдээллийн самбарт байршуулан офицер, ахлагч, ажилтан алба хаагчдад мэдээлэл хүргэх ажлыг зохион байгууллаа. Мөн автын мэргэжлийн офицер, ахлагч нарын тусламжтайгаар байнгын бие бүрэлдэхүүний хувийн автомашинд үзлэг оношилгоо хийх гэх мэт онцлох ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Түүнчлэн Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн хамт олноос Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлж, замын хөдөлгөөндөө дүрмийн дагуу соёлтой оролцож, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” аянд нэгдэхийг уриалж байна.

Ахлагч Б.ЗОЛЗАЯА